



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 5/72

Хэрлэн сум

**Б.Оюунтуяаг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр “Журам батлах тухай” тогтоолоор баталсан ‘Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам’-ын 2.3 дах заалт, 2022 оны 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Архивын тоо бүртгэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалд Базаргүрийн Оюунтуяаг түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Оюунтуяагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Мөнгөнцэцэг	Архивын тасгийн дарга
Гишүүд:	М.Шарагаваа	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Энхтуяа	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3.Б.Оюунтуяагийн цалинг ТЗ-8 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, орон нутаг ажилласны нэмэгдлийн 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Оюунтуяад үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНТУЛГА

